

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Засгийн газрын гишүүд болон холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллагын саналын товъёог

№	Албан бичиг	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх
1	Улсын дээд шүүх 2021.10.05 5/3985	Тусгайлан өгөх саналгүй.	Саналгүй
2	Шүүхийн ерөнхий зөвлөл 2021.09.21 1/817	1.Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь заалтаар шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд хугацааг тогтоох эрхтэй. Үүнтэй холбогдуулан жишиг хугацааг харгалзан шинжилгээ хийх хугацаагаа тогтоодог байх нь зүйтэй. Түүнээс шинжилгээ хийх гэж буй этгээдтэй урьдчилан тохиролцох нь боломжгүй, зохимжгүй юм. 2.Хуулийн 29.3-т шинжилгээний байгууллагад ажилладаггүй хүнийг шинжээчээр оролцуулах зохицуулалт оруулахдаа шинжилгээний байгууллага шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд зөвхөн мэдэгдэнэ гэж байгаа нь учир дутагдалтай. Мэдэгдэх, зөвшөөрөл авах гэж нэмж оруулах. 3.Хуулийн төслийн 49.4-т шинжээчийн үйл ажиллагаанд хориглох зүйлд шинжилгээний зардлаар барьцаалж шинжилгээний хариуг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд хүргүүлэхээс татгалзах гэж оруулах. ИХШХШТХ-ийн 55 дугаар зүйлд шинжилгээ хийлгэх зардлыг төлөх чөлөөлөх, багасгахыг энэ хуулийн заалттай нийцүүлэн өөрчлөх. 4.Төслийн 42.5-д шинжилгээ хийлгэх этгээдийг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээний болон эрүүл мэндийн байгууллагад хүргэнэ гэж заасан байна. Одоо мөрдөгдөж буй ИХШХШТХ-д зааснаар иргэний шүүх нь шинжээч томилохдоо ХХША-г түдгэлзүүлэх зохицуулалт үйлчилж байгаа. Түүнчлэн шүүхэд шинжилгээнд хамрагдах ёстой этгээдийг зохих газар хүргэх хүн хүч байхгүй. Эдгээр нөхцөлөөс шалтгаалан шинжилгээ цагтаа хийгдэхгүй, эсвэл шинжилгээнд хамрагдах этгээд шинжилгээний байгууллагад очоогүйгээс шалтгаалан шинжилгээ хийгдэхгүй байх тохиолдол гардаг. Иймд шинжилгээ хийлгэх этгээдийг шинжилгээний болон эрүүл мэндийн байгууллагад албадан ирүүлэх зохицуулалтыг тусгах	1.Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгт шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийх жишиг хугацааг үндэслэн шинжээчийн саналыг харгалзан шинжилгээ хийх хугацааг тогтоохоор заасан болно. Энэ нь шинжилгээний байгууллагаас гадуур хийх шинжилгээ бөгөөд тухайн байгууллагатай хугацааг тохиролцохдоо шинжилгээ хийх жишиг хугацааг харгалзахаар заасан. Өөрөөр хэлбэл жишиг хугацаанд тааруулж шинжилгээг хийж дүгнэлт гаргах болно. Шүүх шинжилгээ нь шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхой арга аргачлалын дагуу хийгддэг цогц ажиллагаа бөгөөд хугацаагаар хязгаарлаж процессийг алдагдуулах нь тухайн шинжилгээний үр дүнд сөргөөр нөлөөлнө. Түүнчлэн хуулийн төсөлд зааснаар шинжээч нь шинжилгээний дүгнэлтийн үндэслэлийг хариуцахаар заасан болно. Саналыг тусгаагүй. 2.Хуулийн төслийн 29.3-т шинжилгээний байгууллагад ажилладаггүй хүнийг шинжээчээр оролцуулах зохицуулалт оруулахдаа шинжилгээний байгууллага шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд зөвхөн мэдэгдэхээр тусгасан. Өөрөөр хэлбэл шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь шинжилгээний байгууллагад шинжилгээ хийлгэх тогтоолыг хүргүүлэх бөгөөд

	5.Төсөлд шинжилгээний анхдагч, нэмэлт, дахин, мөн шаардлагатай бол ижил, өөр мэргэжлийг багаар 2-5 шинжээчтэй шинжилгээ хийх хэлбэр, төрлийг заажээ. Энэ нь одоо практикт буй, ялангуяа эрүүгийн хэрэгт дахин шинжилгээг 1, 3, 5 шинжээчтэйгээр дараалан хийж байгааг өөрчилж чадаагүй байна. Үүнээс шалтгаалж анхдагч шинжилгээний дараа дахин шинжилгээг гурван ч удаа хийх боломжийг олгож, үүний хэрээр хэрэг шийдэгдэхгүй удааширч буй хандлага үргэлжлэхээр байна. Иймд дахин шинжилгээг хийх тооны хязгаарыг тодорхой тусгах. Энэ нь мөн Шинжилгээг Шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэхэд хамаарах. 6.Өөр шинжилгээний багаар шинжилгээ хийх тохиолдолд шинжилгээ хийх явцыг хариуцах ахлагчийг томилох. 7.Шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэхэд шинжээчийн зардал төлөгдөөгүй үндэслэлээр дүгнэлт гаргахаас татгалзах, гаргасан дүгнэлтээ ирүүлэхгүй байх асуудал их гарч байна. ИХШХШТХ-д болон төсөлд зааснаар энэхүү зардал нь нөхөн төлөгдөх шүүхийн зардал хамаарч байгаа тул нэгэнт шинжилгээ хийхийг зөвшөөрсөн шинжилгээ хийх эрх бүхий этгээд энэ үндэслэлээр шүүхэд дүгнэлт ирүүлэхээс татгалзах эрхгүйг тусгах. 8.Криминалистикийн шинжилгээний харьцуулан шинжлэх эх загварыг хэргийн оролцогчоос албадан гаргуулах зохицуулалтыг тусгах. 9. Хуулийн 16 дугаар зүйлд Шинжилгээ хийлгэх хугацаа 16.2 дахь хэсэгт шинжилгээ хийх хугацааг хуулиар нарийвчлан тогтоож өгөх нь зүйтэй. Учир нь практикт шинжээч томилж хэрэг хянан шийдвэрлэх хугацааг 14 хоног гэж тогтоодог боловч хэргийн оролцогч нар шинжилгээ очиж өгөөд шинжилгээ өгснөөс хойш 14-21 хоногийн дараа дүгнэлт гарна гэж хэргийн оролцогч нарт хэлээд явуулдаг. Шүүгчийн захирамжид заасан хугацаа 14 хоног гэж байхад 14 хоногийн хугацаанд дүгнэлтийг гаргаж ирүүлдэггүй. Иймд хуульд эцэг, эх тогтоох шинжилгээ хийж дүгнэлт гаргах хугацааг тодорхой нарийвчлан зааж өгөх хэрэгтэй байх, шинжилгээ хийх жишиг хугацааг шинжээч өөрөө тогтоох биш хуульчилж шинжилгээ гарах хугацаа тодорхой болж, шинжээчийн дүгнэлт хурдан хугацаанд тогтмол гарах нөхцөл бүрдэнэ.	шинжилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтан хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2-т зааснаар шинжилгээний байгууллагын шинжилгээ хийлгэхээр даалгах эрх бүхий албан тушаалтан шинжээчийн мэргэжил, ажлын дадлага, туршлага, мэргэшсэн байдал, эрдмийн зэрэг, цол, ажлын ачаалал зэргийг харгалзан тухайн хэрэгт хувийн ашиг сонирхолгүй шинжээч, эсхүл шинжээчдийн багт шинжилгээ хийлгэхээр даалгахаар заасан. Саналын дагуу мэдэгдэхээс гадна зөвшөөрөл авах нь шинжилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтны дээрх эрх хэмжээнд халдсан, энэ хуульд заасан шинжилгээний хараат бус байх зарчимтай нийцэхгүй байна. Түүнчлэн шинжилгээг үр дүнд нөлөөлөхөөргүй боломжит богино хугацаанд шуурхай хийж гүйцэтгэхэд нөлөөлөхөөр байна. Иймд саналыг тусгаагүй. 3.Саналын дагуу хуулийн төслийн 49 дүгээр зүйлийн 49.4.10 дахь заалтад “шинжээчийн дүгнэлт” гэж тусгасан. Өөрөөр хэлбэл, шинжээчийн дүгнэлт гарсан бол шинжээч өөртөө дүгнэлт болон шинжилгээний объектыг хадгалахыг хориглохоор заасан. 4.Шүүхийн зохион байгуулалтын арга хэмжээ тул хуулийн төсөлд тусгайлан албадлагын арга хэмжээг тусгах боломжгүй байна. Саналыг тусгаагүй. 5.Саналын дагуу хуулийн төслийн 28.5-д шинжилгээг дахин хийх хязгаарлалтыг тусгасан болно.
--	---	---

	10.Төслийн 16.3 дахь хэсэгт шинжээч энэ хуулийн 16.2-т заасны дагуу тогтоосон хугацаанд шинжээчийн дүгнэлт гаргах боломжгүй бол хугацааг сунгуулах хүсэлтээ хугацаа дуусахаас өмнө шинжилгээний байгууллагын шинжилгээ даалгасан эрх бүхий албан тушаалтанд гаргана гэж заасныг 16.3.дахь хэсэгт шинжээч энэ хуулийн 16.2-т заасны дагуу тогтоосон хугацаанд шинжээчийн дүгнэлт гарах боломжгүй бол хугацааг сунгуулах хүсэлтээ хугацаа дуусахаас өмнө шинжилгээний байгууллагын шинжилгээ даалгасан эрх бүхий албан тушаалтанд заавал гаргана гэж өөрчлөх. 11.Иргэний хэргийн шүүх гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэхэд шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээчийн дүгнэлт голлох нотлох баримт болдог. Шинжээчийн дүгнэлт нь мэргэжлийн нэр томьёо, нэршил хэт их агуулдаг тул хэргийн оролцогч нар уг дүгнэлтийг буруу ойлгож, шинжээчийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй маргах, үүнээс шалтгаалаад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах, хэрэг хянан шийдвэрлэх хуулийн хугацаа хэтрэх тохиолдол шүүхийн практикт их байна. Иймд шинжээч дүгнэлтээ гаргахдаа хэргийн оролцогч нарт илүү ойлгомжтой энгийн үгээр тайлбарлах тухай тус хуулийн 17, 18 дугаар зүйлд тусгаж өгөх нь зүйтэй. 12.Хуулийн 8.3, 8.4 дэх заалтуудыг агуулгын хувьд адил тул нэгтгэх боломжтой, Эдгээрийн аль алиныг нь Хууль зүйн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батлахаар байна. 13.Хуулийн төслийн 11.4.1-ийг дараах байдлаар өөрчлөн найруулах: “11.4.1 шинжээч хуульд заасан шинжээчийн үүргээ биелүүлэхээс удаа дараа /2 удаа/ үндэслэлгүйгээр татгалзсан, эсхүл шаардлага хангаагүй дүгнэлт гаргасан бол 3 сарын хугацаагаар” гэж, Шинжээч удаа дараа үндэслэлгүй татгалзаж байгааг болиулах шаардлагатай гэж үзнэ. 14.Хуулийн төслийн 11.5.4-ийг ...алдаатай гаргасан нь эрх бүхий этгээдийн дүгнэлтээр тогтоогдсон бол гэж нэмэх,	6.Шинжээчийн хараат бус байх зарчим зөрчигдөх тул саналыг тусгаагүй. 7.Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд шинжилгээний зардалтай холбоотой зохицуулалтыг тусгасан бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Саналыг тусгаагүй. 8.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.9 дүгээр зүйлд хэв загвар, дээж авах зохицуулалтыг заасан тул саналыг тусгах шаардлагагүй. 9.Шинжилгээ хийх хугацааг хуулийн төслийн 16 дугаар зүйлд тусгасан бөгөөд шинжилгээ хийлгэхээр шийдвэр гаргаж байгаа этгээд хугацааг тогтоохдоо жишиг хугацааг баримтлах, жишиг хугацааг тухайн шинжилгээ тус бүрээр шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шинжилгээний байгууллагаас боловсруулан Улсын Ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлахаар хуулийн төсөлд тусгасан болно. Мөн уг хугацаанд шинжилгээг хийж, дүгнэлт гаргах боломжгүй бол хугацаа дуусахаас өмнө шинжилгээ хийх хугацааг сунгаж болохоор нарийвчлан хуулийн төсөлд заасан болно. Саналыг тусгаагүй. 10.Хуулийн төслийн 16.3 дахь хэсгийг өөрчлөн найруулахаар ирүүлсэн санал нь агуулгын хувьд адил байх тул саналыг тусгаагүй болно. 11.Шинжилгээ хийх үйл ажиллагааны стандарт шаардлагад дүгнэлтийг хэл найруулгын хувьд хүнд ойлгогдохоор дэлгэрэнгүй, гэрэл зургийн үзүүлэлтээр гаргаж өгөх талаар тусгасан байдаг. Түүнчлэн олон улсын нэршил,
--	--	---

	Алдаатай гаргасан гэдгийг хэн нэг эрх бүхий этгээд тогтоох шаардлагатай, Ерөнхий агуулгаараа зөрчил гаргасан нь Тогтоож байж хариуцлага хүлээлгэнэ. 15. Хуулийн төслийн 12.4.5 гэсэн заалт төсөлд байхгүй байна. Техникийн шинжтэй алдаа байх магадлалтай тул Хуулийн төслийн 12.5-ын заалтаас 12.4.5 гэсэн үгийг хасах 16. Нэн даруй юм уу? 3 хоногийн хугацаа заахгүй бол хугацаа алдах эрсдэлтэй Ямар үндэслэлээр татгалзаж байгаагаа нэн даруй бичгээр мэдэгдэхгүй бол хэрэгт хавсаргах баримт үлддэггүй тул 19.2-т “.... татгалзаж, шинжилгээ хийхээр даалгасан эрх бүхий албан тушаалтанд нэн даруй эсвэл 3 өдрийн дотор бичгээр мэдэгдэх гэж нэмэх” 17. “Хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээтэй бол” гэх заалт нь шинжээчийн хувьд тохиромжгүй тул 19.1.4-ийг хасах 18. Мэдлэгийн хүрээнээс хэтэрсэн тохиолдолд татгалзах эрх тусдаа заасан байгаа тул 19.1.7-д ...мэдлэгийн хүрээнд хамаарахгүй бол гэж нэмэх 19.Хориглосон заалт нэмж оруулахгүй бол хуульд заагаагүй үндэслэлээр татгалзах тохиолдол гардаг тул 19 дүгээр зүйлд “..шинжээч нь хуульд заагаагүй үндэслэлээр шинжилгээ хийхээс татгалзахыг хориглоно” гэсэн заалт нэмэх 20.Хуулийн төслийн 34.1.3-ийг хасах 21.Одоогийн шүүхийн практикт татварын улсын байцаагчийн акт, дүгнэлтийг “эрх бүхий байгууллага” гэж үзэхгүй буцаах тохиолдол байгаа Уг заалтыг ийм байдлаар дэлгэрүүлж тайлбарлах нь ач холбогдолтой, улсын байцаагчийн актыг эрх бүхий байгууллагын дүгнэлт гэдэгт оруулахгүй гэдгээр шинжилгээ хийхээс татгалзсан тохиолдол хэд хэдэн удаа гарсан тул хуулийн төслийн 34.4 тайлбар хэсэгт аудитын байгууллага гэсний дараа гааль татвар санхүү нягтлан бодох бүртгэлийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан гэж нэмэх, 22. Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан шинжилгээ хийлгэх эрх олгосон, 11.4- т заасан шинжилгээ хийх эрхийг түдгэлзүүлсэн, 11.5-д заасан шинжилгээ хийх эрхийг хүчингүй болгосон талаарх мэдээллийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс тухай бүр нийтэд мэдээлж байх, мөн шүүх, цагдаа,	шинжлэх ухааны нэршил, мэргэжлийн нэр томъёо зэрэг нь тухайн мэргэжлийн үг хэллэгээр бичигдэх ёстой байдаг. Санал нь шинжилгээ хийх үйл ажиллагааны стандарт, шаардлагад байдаг тул саналыг тусгайлан тусгаагүй. 12.Хэдийгээр хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.4-т заасан жагсаалтыг батлах эрх бүхий этгээд нь хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байгаа боловч 8.4-т шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдээр хийлгэж болох шинжилгээний жагсаалтыг батлахдаа шинжилгээний байгууллагын саналыг үндэслэхээр заасан тул саналын дагуу дээрх 2 хэсгийг нэгтгэх боломжгүй бөгөөд нэгтгэснээр ойлгомжгүй болохоор байна. Саналыг тусгаагүй. 13.Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.5.1 дэх заалтад “шинжилгээний үйл ажиллагааны стандарт шаардлага хангаагүй” гэж нөхцөлийг, мөн 19 дүгээр зүйлд “энэ хууль заасан үндэслэлээс өөрөөр шинжилгээ хийж дүгнэлт гаргахаас татгалзахыг хориглох” агуулгатай заалтыг тусгасан болно. Саналыг тусгасан. 14.Шинжилгээ хийх үйл ажиллагааны стандарт шаардлага хангаагүй гэж өөрчлөлт оруулав. Саналыг тусгасан. 15.Саналын дагуу өөрчлөлт оруулсан. 16.Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “даруй” гэж нэмж оруулсан. 17.Саналын дагуу өөрчлөлт оруулав.
--	---	---

	прокурор гэх зэрэг шинжилгээ хийлгэх шаардлага гардаг төрийн байгууллагуудад заавал хүргүүлж байх үүргийг энэ зүйл, хэсэгт оруулж өгөх. Төслийн 16 дугаар зүйлд шинжилгээ хийх ерөнхий хугацаа болон түүнийг сунгах хугацааг тодорхой зааж өгөх. Тухайлбал 30 хүртэл хоногоор ерөнхий хугацааг, шаардлагатай бол дахин 30 хоногоор сунгах гэх зэргээр. Хугацаа тодорхой биш байх нь хэрэг, маргаан хянан шийдвэрлэх хугацааг удаашруулах нөхцөл үүсгэж болзошгүй. Төслийн 49 дүгээр зүйл дэх шинжээчид хориглох зүйлд “Шинжээч дүгнэлт гаргахаас өмнө шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдээс шинжээчийн хөлс, зардал гаргуулахаар шаардахыг хориглох” гэсэн хэсэг оруулж өгөх. Практикт хөлс, зардлаа урьдчилан гаргуулахаар шаардах, үүнтэй холбогдуулан дүгнэлтээ ирүүлэхгүй байх тохиолдлууд гарч байсан. 23.Захиргааны хэргийн шүүхийн хувьд төрийн захиргааны байгууллагыг тухайлбал, хөдөө орон нутгийн хувьд мэргэжлийн хяналтын байгууллага, газрын харилцаа барилга хот байгуулалтын газрыг шинжээчээр томилох шаардлага цөөнгүй гардаг. Иймд төслийн 8 дугаар зүйлийн зохицуулалтад шүүхээс төрийн захиргааны холбогдох байгууллагуудыг шинжээчээр томилж болохыг заасан зохицуулалтыг тусгайлан тусгах саналтай байна. Хуулийн төслийн 8 дугаар зүйлд шинжилгээ хийх этгээдийг тодорхойлоход тусгай мэдлэг эзэмшсэн мэргэжилтэн, мэргэжлийн байгууллага хамаарна гэжээ. 24.Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төслийн 16 дугаар зүйлд шинжилгээ хийхийг хуульчилж өгсөн ба шинжилгээ хийх дээд хугацааг хуульд тусгаж өгвөл илүү ойлгомжтой, тодорхой болно. Тус хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт шинжилгээний объектын тоо хэмжээ, шинжилгээний цар хүрээ онцлогийг харгалзан шинжилгээ хийх жишиг хугацааг үндэслэн шинжилгээ хийх хугацааг тогтооно гэжээ. Энэхүү жишиг хугацааг хуульчлах боломжтой эсэх, мөн шинжилгээ хийх хугацаа сунгах үндэслэлийг хуульчлах. 25.“Эдийн засгийн шинжилгээ”, “санхүү бүртгэлийн шинжилгээ” нь хамааралтай байж болох боловч хоёр өөр ойлголт. Одоо үйлчилж буй хуульд буруу томъёолсон байдгийг засах хэрэгтэй.	18.Саналыг тусгасан. 19.Саналыг тусгасан. 20.Саналын үндэслэл тодорхойгүй тул саналыг тусгаагүй болно. 21.Саналыг тусгасан. 22.Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд заасан шинжээчийн эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаарх мэдээллийг нийтэд мэдээлэх үүргийг ХЗДХЯ хүлээхээр болон холбогдох журмыг батлах зохицуулалтыг тусгасан. Харин шүүх шинжилгээ нь тухайн шинжилгээний төрөл, онцлогоос хамааран өөр өөр байх бөгөөд шинжлэх ухааны үүднээс ерөнхий нэг хугацаа тавих нь боломжгүй тул хуулийн төслийн 16 дугаар зүйлд заасан шинжилгээ хийлгэх ерөнхий хугацаа тогтоох саналыг тусгаагүй. Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд шинжилгээний хураамж, зардлыг шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгаж өгсөн бөгөөд хуулийн төсөлд зааснаар шинжилгээний зардлыг 4 төрлөөр шийдвэрлэхээр заасан бөгөөд тухайлбал, эрүүл мэндийн даатгалын сангаас, улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн зардлаар гэх зэрэг болно. Түүнчлэн зардал шаардах зарим төрлийн хохирол шинжилгээг шүүх шинжилгээний байгууллага хийхээр хуулийн төсөлд тусгасан болно. Тухайлбал, хүрээлэн байгаа орчинд учирсан хохирол тооцох үнэлгээ, шинжилгээг шинжилгээний байгууллага хийхээр заасан болно. 23.Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1-д төрийн байгууллагын тусгай мэдлэг эзэмшиж байгаа мэргэжилтэн Мөн хуулийн төслийн 11
--	---	--

		Хуулийн төслийн 4.1.1-д “дүгнэлт гаргах” гэсний дараа “цогц үйл” гэж нэмэх; Учир нь шинжээчийн дүгнэлт гаргах үйл ажиллагаа нь бодит үр дүн гаргахад чиглэсэн өөр хоорондоо холбоотой хэд хэдэн ажиллагаанаас бүрдэж байна. Хуулийн төслийн 4.1.3-т “зэрэг” гэсний өмнө “санхүү бүртгэлийн” гэж нэмэх; Хуулийн төслийн 34 дүгээр зүйлийн “Эдийн засгийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлага” гэснийг “Санхүү, бүртгэлийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлага” гэж өөрчлөх;	дүгээр зүйлийн тайлбарт “мэргэжлийн байгууллага” гэдэг яам, агентлаг зэрэг төрийн байгууллагыг хамруулсан. Үүнийг саналыг дагуу тодотгож өгсөн. Саналыг хэсэгчлэн тусгасан. 24.Шүүх шинжилгээ нь тухайн шинжилгээний төрөл, онцлогоос хамааран шинжилгээ хийх хугацаа нь өөр өөр байна. Иймд уг хугацааг тогтоох үүднээс жишиг хугацааг тогтоож өгсөн бөгөөд энэхүү хугацааг хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.7-д заасны дагуу шүүх шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн Улсын Ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлахаар заасан болно. 25.Хуулийн төслийн 34 дүгээр зүйлд Эдийн засгийн шинжилгээ гэж томъёолж оруулж өгсөн бөгөөд энэ санхүү бүртгэлийн шинжилгээгээр хязгаарлагдахгүй өргөн хүрээгээр хийгдэх шинжилгээ болно. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д саналын дагуу “үйл” гэж нэмсэн болно. Энэ төрлийн шинжилгээ нь зөвхөн санхүү бүртгэлээр хязгаарлагдахгүй бөгөөд “эдийн засаг” гэсэн өргөн хүрээгээр хэрэглэх зүйтэй тул хуулийн төслийн 34 дүгээр зүйлийг эдийн засгийн шинжилгээ гэж өргөн хүрээгээр хэвээр үлдээсэн болно. Саналыг тусгаагүй.
3	Улсын ерөнхий прокурор 2021.09.17	Таны 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 1/3763 дугаартай албан бичгээр ирүүлсэн Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга, дагалдах бусад хуулийн төсөлтэй танилцаад, дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:	1.Шүүх шинжилгээний тухай хууль нь зөвхөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх шинжилгээг хийх бус иргэний, захиргаан, арбитрын хэрэг маргаан, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны

	1/5769	Нэг.Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу 'хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавигдах шаардлагыг хангах, зохицуулалт хоорондын зөрчлийг арилгах чиглэлд анхаарч, нэмэлт боловсруулалт хийх шаардлагатай байна. Тухайлбал: 1.1.Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.1, 19.1.2, 19.1.3, 19.1.4 дэх хэсэгт заасан шинжээчийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзах үндэслэл нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.11 дүгээр зүйлд заасан шинжээчээр оролцож болохгүй үндэслэлтэй агуулгын хувьд зөрчилдөж байх тул холбогдох зохицуулалтын ойлгомжтой байдлыг нэмэгдүүлэх, хууль зүйн техник бичилтийг сайжруулах. 1.2.Хуулийн төслийн 49 дүгээр зүйлийн 49.1.3, 19 дүгээр зүйлийн 19.1.6 дугаар зүйлд заасан нөхцөл шаардлагыг дахин нягталж, зөрүүтэй, ойлгомжгүй байдлыг арилгах; Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн 49.1.3-т “шинжээч нь шинжилгээ хийж дүгнэлт гаргахад шаардлагатай эх хувь, нэмэлт баримт материал ирүүлэхийг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдээс хүсэх” эрхтэй гэсэн бол төслийн 19.1.6-д “шинжээч нь шинжилгээний объект, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах шаардлага хангахгүй бол” шинжилгээ хийж дүгнэлт гаргахаас татгалзахаар заасан нь ойлгомжгүй байна. Иймд хуулийн төслийн 19.1.6 дахь заалтыг “шаардлагатай нэмэлт баримтыг хугацаандаа ирүүлээгүй, нэмэлт баримт шаардлага хангаагүй бол” гэж тодорхой байдлаар өөрчлөн найруулах. 1.3.Хуулийн төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт шүүх эмнэлгийн шинжилгээ хийх нийт дөрвөн тохиолдлыг тодорхой тусгаж өгсөн байна. Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заавал шинжилгээ хийх нийт таван тохиолдлыг тодорхой тусгаж өгснөөс 2.3, 2.4 дэх хэсэгт заасан тохиолдлыг тусгаж өгөөгүй орхигдуулсан нь хууль хэрэглээний хувьд зөрүүтэй, ойлгомжгүй байдлыг үүсгэж байх тул хууль хоорондын уялдаа холбоо, зохицуулалтыг анхаарах. 1.4.Хуулийн төслийн 56 дугаар зүйлийн 56.8, 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэг хоорондоо зөрчилдөж байгааг анхаарах.	явцад шинжилгээг хийдэг бөгөөд хуулийн төслийн 19 дүгээр зүйлд нийтлэг байдлаар шинжээчийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзах үндэслэлийг зааж өгсөн болно. Иймд саналыг тусгаагүй болно. 2.Саналыг хуулийн төслийн 19.1.6, 49.1.3-т тусгасан. 3. Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.1 дүгээр зүйлийн 2.3, 2.4 дэх заалтад заасан шинжилгээ хийлгэх 2 тохиолдолд нь сэтгэцийн шинжилгээ хийлгэх тохиолдол тул хуулийн төслийн 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2-т сэтгэцийн шинжилгээг хийх нөхцөлд тусгаж өгсөн болно. Энэ хууль хэрэглээний хувь зөрчилдөхгүй бөгөөд Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөлд нарийвчлан заасан болно. Саналыг тусгаагүй. 4.Саналыг тусгасан. 5.Саналыг тусгасан. 6.Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд ямар төрлийн шинжилгээний зардлыг улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд зааснаар, зарим төрлийн шинжилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр тодорхой заасан байна. Тухайлбал, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 20¹ дүгээр зүйлд нийт 13 төрлийн шүүх эмнэлгийн шинжилгээнд улсын тэмдэгтийн хураамж авахаар засаан болно. Харин хуулийн төслийн 34, 35, 36, 37, 38 дугаар зүйлд заасан шинжилгээнд зардал тогтоож өгөөгүй улсын тэмдэгтийн хураамж авахгүй.
--	--------	--	--

	Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн 56.8-д “Шинжилгээний байгууллагын албан хаагчийн мэргэжлийн түвшинг үнэлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн бол хуулийн төслийн 61.2-т “Шинжилгээний байгууллагын алба хаагчийн мэргэжлийн түвшин үнэлэх журмыг шинжилгээний төв байгууллагын дарга батална” гэсэн байгааг анхаарах. 1.5.Хуулийн төслийн 33 дугаар зүйлийн 33.9 дэх хэсэгт “Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам, хохирлын зэрэг тогтоох журмыг эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн гарын гишүүн, Улсын ерөнхий прокурортой хамтран батална” гэж заасан нь Прокурорын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.9 дэх хэсэгт заасан “Улсын ерөнхий прокурор нь гэмт хэрэгтэй тэмцэх, зөрчил шалган шийдвэрлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан хуулийн заалтыг хэрэгжүүлэх заавар, журам хуульд нийцэж байгаа эсэхийг хянаж зөвшөөрөл олгох, хэрэгжилтэд хяналт тавих” гэсэнтэй зөрчилдөж байна. Иймд Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам, хохирлын зэрэг тогтоох журмыг эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн гарын гишүүн хамтарч батална гэж өөрчлөн найруулах. 1.6.Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “...шүүх эмнэлгийн шинжилгээний хураамжийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр зохицуулсан. Гэтэл хуулийн төслийн 4 дүгээр бүлгийн 34, 35, 36, 37, 38 дугаар зүйлд заасан зарим төрлийн шинжилгээнд улсын тэмдэгтийн хураамж авах эсэх нь тодорхой бус шинжилгээний хураамж нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж үйлчилгээнд хамаарахгүй байна. Иймд Шүүхийн шинжилгээний байгууллагаар хийгдэж байгаа зарим төрлийн шинжилгээнд улсын тэмдэгтийн хураамж авах эсэх, шинжилгээний төлбөрийн хураамжийг хаанаас санхүүжүүлэх эсэхийг тодорхой болгож зохицуулах. Түүнчлэн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөр хариуцах үйлчилгээ нь зөвхөн даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээ байхаар зохицуулсан бөгөөд хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт эрүүл мэндийн даатгал	Түүнчлэн эрүүл мэндийн даатгал төлдөггүй, эсхүл гадаад улсын иргэнд эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх боломжгүй. Үүнтэй холбоотой зохицуулалтыг саналын дагуу нэмсэн болно. 7.Саналын дагуу хуулийн төслийн 49.1.8-д энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан үндэслэлээр татгалзах гэж өөрчлөв. 8.Саналын дагуу заалтын дугаарлалтад өөрчлөлт оруулсан. 9.Саналын дагуу хуулийн төслийн 12.5-д заасан “12.4.5” гэснийг хассан. 10.Саналын дагуу засварыг тусгасан.
--	---	--

		төлдөггүй монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хамаарах эсэх нь тодорхой бус байх тул хуулийн зохицуулалтыг анхаарах. Хоёр. Хуулийн төслийн эх бичвэрийн найруулгыг сайжруулж, давхардсан, эш татсан зохицуулалтыг нягталж, зөрчил хийдлийг арилгахад анхаарах. Тухайлбал: 2.1.Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.7, 49.1.8 дахь хэсгийн зохицуулалт, агуулгын хувьд хоорондоо давхардсан, нэг утга санааг илэрхийлж байх тул хуулийн зүйл, хэсэг хоорондын зохицуулалтын давхардлыг арилгах. 2.2.Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5.1.48, 5.1.49-д заасан шинжилгээ хийхэд улсын тэмдэгтийн хураамж авна” гэжээ. Гэтэл Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5.1.48, 5.1.49-д шинжилгээтэй холбоогүй буюу Соёлын тухай болон Кино урлагийг дэмжих тухай хуулийн дагуу олгох зөвшөөрлийн асуудлыг зохицуулсан байх тул анхаарч нягтлах. 2.3.Хуулийн төслийн 12.4.1, 12.4.5-д заасан объектын жагсаалтыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн боловч төсөлд 12.4.5 дахь заалт тусгагдаагүй байгааг анхаарах. 2.4.Хуулийн төслийн 31 дүгээр зүйлийн 31.5 дахь хэсэгт “Шинжээчид санал зөрсөн тохиолдолд энэ хуулийн 30.3-т заасны дагуу дүгнэлт гаргана” гэжээ. Гэтэл хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт шинжилгээ хийх дараалал, цар хүрээ, арга зүйг тогтоох талаар тусгасан байна.	
4	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 2021.09.09 01/2101	Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. 1 .Төслийн 10 дугаар зүйлд дараах хэсгийг шинээр нэмэх. “10.8.Энэ зүйлд заасан ажиллагааг зөрчиж шинжээч томилохыг хориглоно.” Одоогоор практикт шинжээч томилох эрх бүхий этгээд нь шинжээчээр ажиллах хүнд санал тавих, мэдлэг чадвартайг нь нотлох, татгалзах үндэслэл, шинжээчээр ажиллахыг зөвшөөрч байгаа эсэхийг урьдчилан тодруулах талаарх хуульд заасан	1.Саналыг тусгасан. 2.”Мэргэжилтэн” нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу оролцоно. Саналыг тусгаагүй. 3.Мэргэжлийн байгууллага гэдгийг хуулийн төслийн 34 дүгээр зүйлийн доор тайлбарласан болно. 4.Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.1-д “гарын үсэг зурж”, 17.4-д шинжээч дангаараа

	ажиллагааг хэрэгжүүлэхгүйгээр тухайн этгээдийг, эсхүл түүнийг ажилладаг байгууллагыг шууд шинжээчээр томилж, бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна. Мөн шинжээч томилох эрх бүхий этгээд нь практикт төрийн байгууллагыг эрхэлсэн чиг үүргийнх нь дагуу шинжээчээр томилж, шинжээчийн дүгнэлт гаргахыг даалгаж байгаа нь зөвхөн шинжээч томилох эрх бүхий этгээд шинжээч (хувь хүн)-ийг томилох, шинжээчийг томилохдоо мэдлэг чадвар, татгалзан гарах үндэслэл, зөвшөөрч байгаа эсэхийг урьдчилан тогтоох ажиллагаа хийх хуулийн зохицуулалттай зөрчилдөж байна. 2.Төслийн 4.1.7-т “мэргэжилтэн гэж... хүсэлтээр оролцох тусгай мэдлэг эзэмшсэн хүнийг” гэж тодорхойлсон боловч төслийн 10 дугаар зүйлд хүсэлт өгөх тухай зохицуулалт тусгагдаагүй, зөвхөн шинжээчээр томилох зохицуулалт тусгагдсан байгааг нягтлах. 3.Төслийн 8.2-т заасан “мэргэжлийн байгууллага” гэснийг хасах, эсхүл ямар байгууллага хамаарахыг тодорхой тусгах. Мөн төслийн 4.1.6, 4.1.7-д “шинжээч, мэргэжилтэн гэж ...хүнийг хэлнэ” гэж томъёолсон боловч төслийн 8.2-т шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээд гэдэгт “байгууллага”-ыг оруулсан нь зөрчлийг үүсгэж байна. Мөн энэхүү саналын 1-т тусгагдсан төрийн байгууллагыг шинжээчээр томилохтой ижил хүндрэл гарахаар байна. 4.Төслийн 17.4-т “Тусгай мэргэжил шаардсан шинжээчээр ажиллаж буй шинжээч, мэргэжилтний гарын үсэг зурснаар хүчинтэйд тооцно.” гэж нэмэх. Шинжээч нь өөрийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд дүгнэлт гаргах бөгөөд хүн бүрд хувийн тэмдэг байхгүй тул хэрэгжих боломжгүй юм. Иймд хувийн тэмдгээр баталгаажуулна гэснийг хасах, эсхүл “болно” гэж өөрчлөх. Практикт улсын байцаагч шинжээчээр ажиллаж гаргасан дүгнэлтэд байгууллагын тэмдэг, эсхүл байцаагчийн тэмдэг дарахыг шаардаж байгаагаас үл ойлголцол, зөрчил үүсгэж байна. Тодруулбал, улсын байцаагч нь байгууллагыг төлөөлж бус тусгай мэдлэг эзэмшсэн хувь хүн гэсэн нэрээр дүгнэлтийг гаргаж байгаа, нөгөөтэйгүүр шинжээчийн дүгнэлт нь улсын байцаагчийн хянан шалгах үндсэн чиг	дүгнэлт гаргасан тохиолдолд гарын үсэг зурж, хувийн тэмдгээр баталгаажуулна.” гэж заасан тул саналыг тусгаагүй болно. 5.Саналыг тусгасан. 6.Саналыг тусгасан.
--	--	--

		үүргийнхээ хүрээнд гаргасан эрх зүйн бичиг баримт биш тул улсын байцаагчийн тэмдэг дарах хориотой байдаг. 5.Төслийн 32.3-т “цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, цөмийн материал” гэж нэмэх, 6.Төслийн 38.1.3 дахь заалтын “Хуулийн этгээд” гэснийг “иргэн, хуулийн этгээд” гэж өөрчлөх	
5	Авлигатай тэмцэх газар 2021.09.14 02/9394	Шүүх шинжилгээний тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөлтэй танилцан дараах саналыг хүргүүлж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.12 дугаар зүйл <i>/Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх нийслэл хотын хот тохижилт, авто замын засвар, арчилгаа, хог хаягдалтай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй/-ийг зохицуулсан байна.</i> Зарчмын хувьд дээрх хуулийн заалтын нэмэлт өөрчлөлтийг дэмжих боломжгүй юм. Тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 /Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй/-т зааснаас бусад худалдан авалтыг Төсвийн тухай хуульд худалдан авах ажиллагааны зардал батлагдсан бол төлөвлөлт хийгдэж тендер сонгон шалгаруулалт явуулах боломжтой. 2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн 19.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг “прокурор” гэснийг “мөрдөгч” гэж өөрчлөх. Шинжилгээ хийх үедээ төлбөр төлсөн байх шаардлага тавьдаг бөгөөд зардлыг хэн гаргах нь тодорхойгүй. Прокурор, шүүхийн шийдвэрээр хийгдсэн ажиллагааны төлбөрийг мөрдөх ажиллагаа хийсэн байгууллагын байцаан шийтгэх ажиллагааны зардлаас байгууллага төлдөг. Энэ зардал нь тус байгууллагаас гарах зардал биш эрх бүхий хяналтын байгууллагаас акт тавигдаж төлбөр төлөх нөхцөл үүсдэг. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор, мөрдөгч нь өөрийн санаачилгаар, эсхүл оролцогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл эрүүгийн	1.Сангийн яамны саналын дагуу Шүүх шинжилгээний байгууллагын худалдан авалт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар зохицуулах зохицуулалтыг хэвээр хадгалж, Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийг даган боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хаслаа. 2.Саналыг тусгасан. 3.Хуулийн төслийн 34 дүгээр зүйлийн тайлбарт байгууллагын дотоод аудитын нэгжийн гаргасан акт, дүгнэлтэд эдийн засгийн шинжилгээний хийхээр заасан тул саналыг тусгаагүй. Мөрдөгчийн магадлагаа нь эдийн засгийн шинжилгээг хийх анхан шатны баримт болохгүй. Харин мөрдөгчийн магадлагааг оруулаагүй болно. 4.Саналыг тусгасан. 5.Саналын дагуу удаа дараа гэдгийн 2 ба түүнээс дээш гэж оруулсан болно.

		хэрэг хянан шийдвэрлэхэд тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах асуудлыг тодруулахаар, эсхүл эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоох шинжилгээ хийлгэхээр шинжээч томилно” гэсэн заалттай зөрчилдөж байх тул хуулийг нэг ойлгохоор өөрчлөн найруулах замаар хуулийг уялдуулах; Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.3.3 “эдийн засгийн шинжилгээний объектын хувьд эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргасан байх” гэсэн заалт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.11 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Мөрдөгч энэ хуулийн 27.1 дүгээр зүйлд заасан шинжилгээг шинжээч томилж хийлгэх шаардлагагүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулж тогтоох боломжтой, эсхүл өөрийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд тогтоох боломжтой гэж үзвэл магадалгаа гаргаж болно” гэсэн заалттай зөрчилдөж байна. Гэтэл дээрх байгууллагыг шинжээчээр томилж дүгнэлт гаргуулах, мөрдөгч магадалгаа гаргасан, байгууллагын дотоод аудитор гаргасан акт дүгнэлт хамаарахгүй байгаа учир хуулийн төслийн 12.3.3 дахь хэсэгт дээр дурдсан актуудыг нэмэх, шинжилгээний байгууллагаас гадуур эдийн засгийн шинжилгээ хийлгэсэн бол акт дүгнэлт шаардсан хэсгийг хасах, хуулийн төслийн 34 дүгээр зүйлийг баримтлах боломжтой юм. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.4.1 “шинжээч хуульд заасан шинжээчийн үүргээ биелүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүй дүгнэлт гаргасан бол гурав хүртэл сарын хугацаагаар” гэснийг “гурав сараас 6 сар хүртэл” гэж оруулах; Хуулийн төслийн 63.3.5 хэсгийн “удаа дараа” гэсний /хуульд өөрөөр заагаагүй 5ол 3 ба түүнээс дээш/ шинжилгээний шаардлага хангахгүй... гэж нэмж оруулах саналыг хүргүүлж байна.	
6	Монголын өмгөөлөгчдийн холбоо 2021.09.30 01/1358	1.Шүүх шинжилгээний хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгээс Цагдаагийн албаны тухай хуулийг хасах 2. Хуулийн төслийн 10.2-т “шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь энэ хуулийн 8.2-т заасан этгээдэд шинжилгээ хийлгэх санал тавьж, хувийн баримт бичиг, тусгай мэдлэг мэргэжил, чадварыг нотолсон баримт бичиг, шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзах үндэслэл, шинжээчээр ажиллахыг зөвшөөрч байгаа эсэхийг урьдчилан тодруулж, энэ тухай баримтжуулна.” гэсэн	1.Цагдаагийн албаны тухай хуулиар шүүх шинжилгээний алба хаагчид цол олгох, түдгэлзүүлэх, цолыг хасах, хураах, дайчилгаанд ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулах тул саналыг тусгаагүй. 2.Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд шинжилгээний хураамж, зардлыг шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг

	хэсэгт “шинжээчээр ажиллах хөлсийг тохиролцон олгосны дараа” гэж нэмэх, 3.төслийн 31.5-д “шинжээчид санал зөрсөн тохиолдолд энэ хуулийн 30.3-т заасны дагуу дүгнэлт гаргана.” гэж заасны “30.3” гэснийг “30.4” гэж өөрчлөх 4.Төслийн 33.1.1-д “гадны нөлөөгөөр, эсхүл сэжигтэй байдлаар хүн нас барсан бол түүний шалтгааныг тогтоох гэсэн заалтад “нас барсан хугацааг тогтоох” гэж нэмэх, 5.төслийн 33.5-д “цогцост шүүх дүрс оношилгооны шинжилгээ хийсэн тохиолдолд үр дүн нь шинжээчийн дүгнэлт гаргахад хангалттай бол цогцост шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийхгүй байж болно.” гэж заасан байна. Энэ тохиолдолд цогцосыг CT, MRI төхөөрөмжийн шинжилгээгээр бүтэн сканнердаж мэдээллийг цахим санд архивлан хадгална.” гэж нэмэх,	тусгаж өгсөн бөгөөд хуулийн төсөлд зааснаар шинжилгээний зардлыг 4 төрлөөр шийдвэрлэхээр заасан бөгөөд тухайлбал, эрүүл мэндийн даатгалын сангаас, улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн зардлаар гэх зэрэг болно. Иймд саналыг тусгаагүй болно. 3.Саналыг тусгасан. 4.Саналыг тусгасан. 5.Хуулийн төсөлд адил агуулга бүхий зохицуулалт байх тул саналыг тусгаагүй.
--	--	---

---o0o---